

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Огноо: 2020.02.14

ЛИЦЕНЗТЭЙ ПРОГРАММ, ТӨРИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

ЛИЦЕНЗТЭЙ ПРОГРАММ, ТӨРИЙН НЭГДСЭН
СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
НИЙЛҮҮЛЭХ

Харьцуулалт/

гэрээний дугаар:

АЕГ/ХА/2020/01

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 02 дугаар сарын 14

Тендер шалгаруулалтын нэр: “Лицензтэй программ, төрийн нэгдсэн сүлжээнд холбогдох тоног төхөөрөмж” нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: АЕГ/ХА/2020/01

Архивын ерөнхий газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос лицензтэй программ, төрийн нэгдсэн сүлжээнд холбогдох тоног төхөөрөмж нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 10 цагаас өмнө Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр (PDF) ирүүлнэ.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстай.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй.

Сонирхсон этгээд мэдээллийг доорх хаягаар авч болно: Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Улаанбаатар хот 17121, Монгол улс, Архивын ерөнхий газар №304, мэргэжилтэн Ц.Долгормаа, утас: 99735621, 77002053.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг. (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохироулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТОӨЗ-НЫХОЛБОГДОХЗААЛТ | Шалгуур үзүүлэлт |
|------------------------------|--|
| ТОӨЗ 1.1 | <p>Сүүлийн 1 жилийн /2019 он/ жилийн санхүүгийн баталгаажсан тайлан</p> <p>Сүүлийн 2 жилийн /2018, 2019 он/ туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн актны хуулбар/</p> <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/ - Энэхүү ТББ дах жишиг маягтын дагуу гаргаж баталгаажуулсан үнийн санал, техникийн тодорхойлтод заасан барааг гэрээний хугацаанд нийлүүлэх тухай тодорхойлолт ирүүлэх - Харилцагч болон бусад арилжааны банкнуудын тодорхойлолт - ШИШГЕГ-ын тодорхойлолт - Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архивын тодорхойлолт |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Архивын ерөнхий газар, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Улаанбаатар хот 17121, Монгол улс</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3 давхар, №304</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p> |
| ТОӨЗ 2.2 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Архивын ерөнхий газар, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Улаанбаатар хот 17121, Монгол улс</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 4 давхар, №403</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p> |
| ТОӨЗ 6.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Багц 1: Лицензтэй программ хангамж</p> <p>Багц 2: “Галт хана”-д зориулсан лиценз</p> <p>Багц 3: Төрийн нэгдсэн сүлжээнд холбогдох тоног төхөөрөмж</p> |

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

Багц 1: Лицензтэй программ хангамж

| № | Нэр | Үзүүлэлт |
|---|--|---|
| 1 | Kaspersky antivirus 2019: 2 төхөөрөмж /1 жил/ | Вирусны эсрэг программ 2 төхөөрөмжинд зориулсан |
| 2 | Kaspersky endpoint security for business /1 жил/ | Серверт зориулсан вирусны эсрэг программ |
| | Дээрх үзүүлэлттэй дүйцэхүүц илүү сайн | |

Багц 2: Лицензтэй программ хангамж

| № | Нэр | Үзүүлэлт |
|---|---|---|
| 1 | Галт хана WatchGuard Firebox M300-д зориулсан 1 жилийн лиценз /1-year Basic Security Suite/ | Галт хана “WatchGuard Firebox M300”-д зориулсан 1 жилийн лиценз /1-year Basic Security Suite/ |
| | Дээрх үзүүлэлттэй дүйцэхүүц илүү сайн | |

Багц 3: Төрийн нэгдсэн сүлжээнд холбогдох тоног төхөөрөмж

| № | Нэр | Үзүүлэлт |
|---|---|---|
| 1 | Switch /Cisco WS-C3560CG-8PC-S/ | Төрийн албан хэрэглээний сүлжээнд шаардлагатай: “Cisco WS-C3560CG-8PC-S” Свич |
| 2 | Switch /Cisco WS-C2960CX-8TC-L/ | Төрийн интернет хэрэглээний сүлжээнд шаардлагатай: “Cisco WS-C2960CX-8TC-L” Свич |
| 3 | Transceiver /GLC-LH-SMD single mode, duplex/ | Төрийн албан хэрэглээний сүлжээнд шаардлагатай: Transceiver / Cisco GLC-LH-SMD single mode, duplex/ |
| 4 | Transceiver /GBX 20 SFP-A single mode, single strand/ | Төрийн интернет хэрэглээний сүлжээнд шаардлагатай: Transceiver / Cisco GBX 20 SFP-A single mode, single strand/ |
| 5 | Transceiver /GBX 20 SFP-B single mode, single strand/ | Төрийн интернет хэрэглээний сүлжээнд шаардлагатай: Transceiver / Cisco GBX 20 SFP-B single mode, single strand/ |
| 6 | Jumper кабель /SC-LC 5м/ | SC-LC оптик холбогчтой (адаптер) шилэн кабель 5м |
| | Дээрх үзүүлэлттэй дүйцэхүүц илүү сайн | |

2. **Стандарт:** Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно
3. **Баглаа, боодол:** Үйлдвэрийн баглаа боодолтой байна.
4. **Бараа хүргэх газар:** Архивын ерөнхий газар, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Улаанбаатар хот 17121, Монгол улс.
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|--|------------|-------------|--|---|---|--------------------------------------|
| | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Багц 2: “Галт хана”-д зориулсан лиценз | | | | | | |
| Kaspersky antivirus 2019: 2 төхөөрөмж /1 жил/ | 60 | ширхэг | Архивын ерөнхий газар | Гэрээ байгуулснаас хойш ажлын 7 хоногт | Гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногт | |
| Kaspersky endpoint security for business /1 жил/ | 2 | ширхэг | Архивын ерөнхий газар | Гэрээ байгуулснаас хойш ажлын 7 хоногт | Гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногт | |
| Багц 3: Төрийн нэгдсэн сүлжээнд холбогдох тоног төхөөрөмж | | | | | | |
| Switch /Cisco WS-C3560CG-8PC-S/ | 1 | ширхэг | Архивын ерөнхий газар | Гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногт | Гэрээ байгуулснаас хойш ажлын 30 хоногт | |
| Switch /Cisco WS-C2960CX-8TC-L/ | 1 | ширхэг | Архивын ерөнхий газар | Гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногт | Гэрээ байгуулснаас хойш ажлын 30 хоногт | |
| Transceiver /GLC-LH-SMD single mode, duplex/ | 1 | хос | Архивын ерөнхий газар | Гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногт | Гэрээ байгуулснаас хойш ажлын 30 хоногт | |
| Transceiver /GBX 20 SFP-A single mode, single strand/ | 1 | ширхэг | Архивын ерөнхий газар | Гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногт | Гэрээ байгуулснаас хойш ажлын 30 хоногт | |
| Transceiver /GBX 20 SFP-B single mode, single strand/ | 1 | ширхэг | Архивын ерөнхий газар | Гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногт | Гэрээ байгуулснаас хойш ажлын 30 хоногт | |
| Jumper кабель /SC-LC 5m/ | 6 | ширхэг | Архивын ерөнхий газар | Гэрээ байгуулснаас хойш ажлын 14 хоногт | Гэрээ байгуулснаас хойш ажлын 30 хоногт | |

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тандерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[тоо]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал Үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тандерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

| | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [багц 3-ын хувьд 6 сар ба түүнээс дээш] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш гэрээнд заасны дагуу хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) барааг хүргэсэн тухай баримт; 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; 5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> | |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: <p>Гэрээний үнийн дүнгийн хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: 0,5 Алдангийн нийт дүн: 10 |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____-ны сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүний хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]